



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Завхан-АЗЗА” ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2025/003/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай сум 2025 он</p>	<p>Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn Аудитын менежер: Х.Болдбаатар Утас: 99105506 Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Оюунсүвд Утас: 99076038 Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Компани, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

“ЗАВХАН-АЗЗА” ТӨХК-ИЙН
ЗАХИРАЛ Г.БАТТУЛГА-Д

2025.03.14 № 334

танай _____ -ны № _____ -г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Завхан-АЗЗА” ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлого үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн байдал, орлого үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудыг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Богино хугацаат өр төлбөр өмнөх оноос 144.9 сая төгрөгөөр, үйл ажиллагааны алдагдал 312.5 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Энэ нь 2024 онд аймгийн хэмжээнд зуд болж улсын чанартай авто зам, замын байгууламжид өвлийн арчлалтын онцгой ажлыг гүйцэтгэсэн боловч яамнаас 450.0 сая төгрөгийн санхүүжилт хасагдсантай холбоотой байна.

Аудитын гол асуудал

“Завхан-АЗЗА” ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлого үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, тодруулгууд болон эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

Бусад асуудал

Зам, тээврийн яамтай 1203 км улсын чанартай авто замын урсгал засвар, арчлалтыг хариуцан гүйцэтгэхээр 1,842.3 сая төгрөгийн, 20 км авто замын засварын ажлыг гүйцэтгэхээр 180.1 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулсан байна.

Мөн Цэцэрлэг-Тосонцэнгэл-Нөмрөг чиглэлийн улсын чанартай авто замын дагуу авто зогсоол байгуулах ажлыг 358.8 сая төгрөгөөр, улсын чанартай авто замын дагуу мэдээлэх самбар шинээр байршуулах ажлыг 45.7 сая төгрөгөөр тус тус гүйцэтгэжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д. БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Үзүүлэлтийн нэр	Үлдэгдэл	
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1.Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	190,480,020.50	2,089,700.72
1.1.2. Дансны авлага	0.01	5,859,242.01
1.1.11. Эргэлтийн хөрөнгийн дүн	551,112,691.43	419,901,867.34
1.1.3. Татвар НДШ-ийн авлага	1,260,847.61	0.00
1.1.4. Бусад авлага	119,020,113.18	117,510,135.78
1.1.6. Бараа материал	214,315,710.13	268,442,788.83
1.1.7. Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	26,036,000.00	26,000,000.00
1.2.1 Үндсэн хөрөнгө	922,366,161.16	952,634,529.70
1.2.2 Биет бус хөрөнгө	95,696,000.00	98,633,500.00
1.2.12 Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,018,062,161.16	1,051,268,029.70
1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,569,174,852.59	1,471,169,897.04
2.1.1.1 Дансны өглөг	244,632,633.33	273,520,906.00
2.1.1.2 Цалингийн өглөг	28,785,137.26	0.00
2.1.1.3 Татварын өр	187,027,509.98	331,847,998.59
2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн	460,445,280.57	605,368,904.59
2.1.2.5 Зээл	291,360,199.00	291,360,199.00
2.1.2.6 Урт хугацаат өр төлбөрийн дүн	291,360,199.00	291,360,199.00
2.2 Өр төлбөрийн нийт дүн	751,805,479.57	896,729,103.59
2.3 Эздийн өмч	431,714,192.00	431,714,192.00
2.3.1 Төрийн	431,714,192.00	431,714,192.00
2.3.6 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	73,020,780.11	73,020,780.11
2.3.8 Эздийн өмчийн бусад хэсэг	647,638,311.76	724,539,870.56
2.3.9 Хуримтлагдсан ашиг	-335,003,910.85	-654,834,049.22
2.3.11 Эздийн өмчийн дүн	817,369,373.02	574,440,793.45
2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,569,174,852.59	1,471,169,897.04

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Үзүүлэлтийн нэр	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
1. Борлуулалтын орлого(Цэвэр орлого)	2,274,507,523.64	2,476,928,066.36
2. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,933,442,281.59	2,286,632,582.76
3. Нийт ашиг (алдагдал)	341,065,242.05	190,295,483.60
5. Хүүгийн орлого	24,424.01	24,727.88
8. Бусад орлого	0.00	897,600.00
9. Борлуулалт, маркетингийн зардал	167,000.00	0.00
10. Ерөнхий ба удирдлагын зардал	330,975,450.25	503,789,817.79
12. Бусад зардал	16,264,880.69	7,258,132.06
18. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(6,317,664.88)	(319,830,138.37)
19. Орлогын татварын зардал	992,279.18	0.00
20. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	(7,309,944.06)	(319,830,138.37)
22. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(7,309,944.06)	(319,830,138.37)
23. Бусад дэлгэрэнгүй орлого	25,000,000.00	76,901,558.80

Бусад олз (гарз)	25,000,000.00	76,901,558.80
24. Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	17,690,055.94	(242,928,579.57)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2024 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	431,714,192	73,020,780.11	647,638,311.76	-335,003,910.85	817,369,373.02
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-319,830,138.37	-319,830,138.37
6	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	76,901,558.80	0.00	76,901,558.80
9	2025 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	431,714,192	73,020,780.11	724,539,870.56	-654,834,049.22	574,440,793.45

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Үзүүлэлтийн нэр	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	2,618,377,190.01	2,727,691,700.88
1.1 Мөнгөн орлогын дүн	2,618,377,190.01	2,727,691,700.88
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,853,259,433.36	2,527,172,650.00
Бусад мөнгөн орлого	765,117,756.65	200,519,050.88
1.2 Мөнгөн зарлагын дүн	2,407,677,124.89	2,816,682,020.66
Ажиллагчдад төлсөн	471,667,359.87	642,096,067.40
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	60,367,546.03	134,240,495.27
Бараа материал худалдан авахад төлсөн	414,437,851.66	990,314,238.12
Ашиглалтын зардал төлсөн	229,350,536.28	44,291,753.56
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	545,380,493.43	850,509,533.00
Хүүгийн төлбөрт төлсөн	0.00	3,000,000.00
Татварын байгууллагад төлсөн	93,060,457.10	133,364,101.25
Даатгалын төлбөрт төлсөн	53,320,110.14	754,950.00
Бусад мөнгөн зарлага	540,092,770.38	18,110,882.06
1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	210,700,065.12	(88,990,319.78)
Мөнгөн зарлагын дүн	15,000,000.00	69,400,000.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	15,000,000.00	66,100,000.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	3,300,000.00
2.20 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(15,000,000.00)	(69,400,000.00)
3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(6,033,400.00)	(30,000,000.00)
Мөнгөн орлогын дүн	0.00	6,000,000.00
Зээл авсан өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	6,000,000.00
Мөнгөн зарлагын дүн	6,033,400.00	36,000,000.00
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	6,033,400.00	36,000,000.00
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	6,033,400.00	30,000,000.00
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	189,666,665.12	(188,390,319.78)
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	813,355.38	190,480,020.50
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	190,480,020.50	2,089,700.72

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Д.д	Үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 оны гүйцэтгэл	2024 он	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл
А	Б	В	1	2	3
1	Нийт орлого	мян.төг	2,274,531,947.7	2,586,830,500.0	2,477,850,394.24
	Үүнээс: Улсын чанартай ЗЗА	мян.төг	1,676,605,447.7	1,886,830,500.0	2,477,850,394.24
	Бусад	мян.төг	597,926,500.0	700,000,000.0	-
2	Нийт зардал	мян.төг	2,280,849,612.5	2,560,962,000.0	2,797,680,532.61
3	Удирдлагын зардалд	мян.төг	330,975,450.3	447,753,523.0	503,789,817.79
4	Татварын өмнөх ашиг	мян.төг	(6,317,664.9)	25,868,312.00	(319,830,138.37)
5	Цэвэр ашиг/ алдагдал/	мян.төг	(7,309,944.1)	23,281,470.00	(319,830,138.37)
6	Төсвийн төлбөрт	мян.төг	153,428,003.1	274,994,600.0	267,604,596.52
	а/Орлогын татварт	мян.төг	992,280.0	1,043,425.0	
	б/НӨАТ	мян.төг	42,691,975.00	85,014,821.0	87,465,976.05
	в/НДШ	мян.төг	60,367,546.0	145,203,852.0	134,240,495.27
	г/ХАОТатварт	мян.төг	42,141,602.1	37,313,017.0	44,390,673.20
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татварт	мян.төг	1,430,000.0	1,200,000.0	1,357,652.00
	э/Тээврийн хэрэгслийн татварт	мян.төг	1,546,000.0	1,654,250.0	149,800.00
	и/Бусад татварт	мян.төг	4,258,600.0	3,565,235.0	
7	Төрийн өмчийн ноогдол ашиг	мян.төг	0	11,640,700.0	-
8	Нийт авлага	мян.төг	120,280,960.8	162,064,000.0	123,369,377.78
9	Нийт өглөг	мян.төг	751,805,479.6	316,514,199.0	896,729,103.59
	Үүнээс. 8.1 богино хугацаат	мян.төг	460,445,280.6	25,154,000.0	605,368,904.59
	8.2 Урт хугацаат өр төлбөр		291,360,199.0	291,360,199.0	291,360,199.0
10	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	төг	1.120	0.990	1.08
11	Хөрөнгө оруулалт	мян.төг	73,800,000.0	46,400,000.0	69,400,000.00
12	Ажиллагсдын тоо	хүн	44	44	44.00
13	Цалингийн сан		525,141,480.0	691,608,358.0	654,198,331.31

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани/ТӨҮГ, түүний үйл ажиллагаа

“Завхан-АЗЗА” ТӨХК нь төрийн захиргааны төв байгууллагаас баталгаажуулсан улсын чанартай авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтыг төрийн захиргааны төв байгууллагатай байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэж, түүгээр өнгөрч байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг жилийн туршид саадгүй байлгах үүрэг бүхий Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын харьяа байгууллага юм.

2024 онд улсын чанартай авто замын урсгал засвар, арчлалтыг хариуцан 1,842.3 сая төгрөгийн ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн байна.

3.2 Компани/ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин

“Завхан-АЗЗА” ТӨХК нь үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Авто замын тухай хууль, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны

тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай зэрэг хуулиудыг голлон мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Завхан-АЗЗА” ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

“Завхан-АЗЗА” ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 98.0 сая төгрөгөөр буюу 6.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	190,480.0	2,089.7	(188,390.3)
Авлага	120,281.0	123,369.4	3,088.4
Урьдчилж төлсөн зардал	26,036.0	26,000.0	(36.0)
Бараа материал	214,315.7	268,442.8	54,127.1
Үндсэн хөрөнгө	1,018,062.2	1,051,268.0	33,205.8
Нийт хөрөнгө	1,569,174.9	1,471,169.9	(98,005.0)
Өр төлбөр	751,805.5	896,729.1	144,923.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	817,369.4	574,440.8	(242,928.6)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,569,174.9	1,471,169.9	(98,005.0)

Дээрх хүснэгтээс харахад дараах данснуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө өмнөх оноос 188.4 сая төгрөгөөр буурсан нь өмнөх онд зам арчлалтын санхүүжилт оройтож орж ирсэнтэй холбоотой үүссэн өглөгийг барагдуулсантай холбоотой байна.
- Урьдчилж төлсөн зардал өөрчлөгдөөгүй нь 2022 онд Агуйтын хөтлийн шуурхайн хэсэгт 26.0 сая төгрөгөөр байр барих ажил хийгдсэн хэдий ч газрын гэрчилгээтэй холбоотой маргаан үүссэний улмаас хүлээн авч, данс бүртгэлд тусгаагүй байна.

- Бараа материал 54.1 сая төгрөгөөр өссөн нь үндсэн материал, шатах тослох материалын үлдэгдэл өссөн нь гол нөлөөг үзүүлж байна.
- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 33.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд 76.9 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй нийлүүлэгдсэн, 65.3 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан, хөрөнгийн элэгдлийн зардал 111.9 сая төгрөгөөр тооцсон зэрэгтэй холбоотой байна.
- Өр төлбөр өмнө оноос 144.9 сая төгрөгөөр өссөн нь яамнаас улсын чанартай авто зам, замын байгууламжид өвлийн арчлалтын онцгой ажлын санхүүжилт хасагдсантай холбоотой байна гэж үзлээ.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2023 оны 783 дугаар тогтоолоор 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 2,586.8 сая төгрөгөөр, нийт зардлыг 2,561.0 сая төгрөгөөр төлөвлөж, 23.3 сая төгрөгийн ашигтай ажиллахаар баталсан байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 7.0 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 2,477.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,797.7 сая төгрөгийн зардал гарган, 319.8 сая төгрөгийн татвар төлөхийн өмнөх алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 2,477.9 сая төгрөг болж төлөвлөснөөс 108.9 сая төгрөг буюу 4.2 хувиар, нийт зардлын гүйцэтгэл 2,797.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 236.7 сая төгрөг буюу 9.2 хувиар өссөн нь 2024 онд аймгийн хэмжээнд зуд болж улсын чанартай авто зам, замын байгууламжид өвлийн арчлалтын онцгой ажлыг гүйцэтгэсэн боловч яамнаас санхүүжилт хасагдсантай холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын арга хэмжээний хүрээнд 65.2 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, 76.9 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй шилжиж ирсэн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 319.8 сая төгрөг болж өмнөх оноос 97.7 хувиар өссөн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Завхан-АЗЗА” ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх компани/ТӨҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Завхан-АЗЗА” ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайлангаа Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 09 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн 2,407.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 24.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардал 2,816.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 28.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 21.1 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 43 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Завхан-А33А” ТӨХК-ийн 2024 оны хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн аудитаар хуримтлагдсан ашиг дансны үлдэгдлийг 235.7 сая төгрөгөөр залруулах зөвлөмж өгч, хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1	235,722.0	1	235,722.0	100%
Нийт дүн	1	235,722.0	1	235,722.0	100%

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Кувейтын сангийн хөнгөлөлттэй зээлээр санхүүжигдэн 2009 онд нийлүүлэгдсэн машин механизм, тоног төхөөрөмжийн 291.4 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөр болон 2020-2021 онд “Завхан-АЗЗА” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан албан тушаалтанд холбогдох 117.5 сая төгрөгийн авлагын барагдуулалтыг анхаарах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй

5.2 Албан шаардлага өгөгдөөгүй

5.3 Зөвлөмж өгөгдөөгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	АТТ	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	АТТ	Тоо	Дүн
Дүн												

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Огноо: 2025-03-14

Д.БАТ-УНДРАА

Х.БОЛДБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

Огноо: 2025-03-14

Ц.ОЮУНСУВД